



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Далайн захиргаа" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн нийт 71,430,000.00 (далан нэгэн сая дөрвөн зуун гучин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд "Далайн захиргаа" улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга С.Түвшинтөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу улсын төсвийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА:

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

300733



Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 07
дугаар сарын 06-ний өдрийн 371 дүгээр
тогтоолын хавсралт

**"Далайн захиргаа" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт**

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглал тад орсон он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	катер 638 маркийн ХӨ М01 улсын дугаартай, моторт завь, хөдөлгүүр дугаар 1F-880428	2007	47,950,000.00	1,000,000.00
2	Ниссан маркийн, суудлын автомашин, 09-60 УНҮ улсын дугаартай, Арлын дугаар JN1TBN30Z0011283	2003	23,480,000.00	3,000,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		71,430,000.00 (далан нэгэн сая дөрвөн зуун гучин мянга)	4,000,000.00 (дөрвөн сая)